



# Гал 11

Гал нь үйлдвэр, дотуур байр, гэр орон болон үйлдвэрийн ажилчдын хувьд ноцтой, бүр үхлийн аюултай зүйл юм. Ажилчдын нүүр тулж байгаа олон аюул дотроос галын аюулаас хамгийн амархан урьдчилан сэргийлж, тохиолдсон үед нь галын хороор унтрааж болдог. Ихэнх улсад ажилчдын ажлын байрны аюулгүй байдлыг хангах талаар хуульчилсан байдаг. Үүнийг ажилчид дагаж мөрдөх нь тийм ч хэцүү биш боловч олон үйлдвэрийн эзэд галын аюулгүй байдлын тухай хуулийг зөрчиж, ажилчдын амь насыг аюулд оруулсаар байна.



## Галаас урьдчилан сэргийлэх

Олон улсын болоод улс орнууд, муж улсуудын хууль, стандарт шинэчлэгдсэнээр ажлын байрны аюулаас гадна олон удаагийн галын аюулаас урьдчилан сэргийлж байна. Хэдий танай улсын эрх баригчид эдгээр аюулгүй байдлын стандартыг хэрэгжүүлэхийг шаардахгүй байсан ч та бүхэнд болон ажилчид, үйлдвэрийн менежерүүдэд ажлын байрны галын эрсдэлийг багасгах олон арга бий. Галын аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж, ажилчид, менежерүүдтэйгээ хамтран ажиллаж, үйлдвэрийн аюулгүй байдлын талаар үүрэг хариуцлагаа хуваарилан авах ёстой юм.



Энэ үйлдвэр галаас урьдчилан сэргийлэх ажлыг сайн хийсэн байна

## Уусгагчийг аюулгүй хадгалах

Уусгагч бодис нь бараг бусад бүх зүйлээс илүү хамгийн хурдан гал авалцдаг чанартай тул галаас урьдчилан сэргийлж, аюулгүй хадгалах хэрэгтэй:

- Үргэлж галд тэсвэртэй саванд, сайтар таглаж хадгал;
- Дотуур байр, шат, галын аюулгүйн гарцын ойролцоо хэзээ ч хадгалж болохгүй;
- Бусад химийн бодис эсвэл амархан гал авалцах материал, даавуу, хөөсөн дулаалгын хажууд хадгалж болохгүй;
- Халуун багаж, тоног төхөөрөмж эсвэл халуун болон оч үүсгэгч эх үүсвэрийн хажууд хадгалах буюу хэрэглэж болохгүй;
- Ажлын байранд жижиг савнуудад хадгал. Том саванд хадгалахдаа агааржуулалтын сайн системтэй, галд тэсвэртэй химийн бодис хадгалах өрөөнд, ажлын орчноос хол хадгал.

Засвар үйлчилгээ сайн хийснээр галаас урьдчилан сэргийлнэ:

- Ажлын байрнаас цаас, тоос, даавууны өөдөс, картон хавтан болон бусад амархан гал авалцах зүйлсийг зайлзуул;
- Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сайтар засаж, аюулгүй байршуул;
- Эвдэрсэн болон элэгдсэн цахилгааны утаснуудыг тэр даруй соль эсвэл зас;
- Гал авалцах даавуу, химийн бодисын тоосонцор эсвэл газ, керосин, пропаны савны ойролцоо тамхи татааж болохгүй;
- Дотуур байрны хөшиг, ор дэрний хэрэгсэл, хувцас зэргийг шарах шүүгээ, халаагч, гэрэл зэргээс хол байлга;
- Галын аюулгүй байдлын чадавхыг сайжруул.

## Гал гарсан тохиолдолд бэлтгэлтэй байх

Дараах зүйлс үйлдвэрт байснаар олон хүний амийг аварч чадна:

- **Галын дохиолол** нь чанга дуу чимээ гаргаснаар бүгд гал гарсныг мэдэх болно. Байшингийн өөр хэсэгт байгаа ажилчдад өөр газар гал гарсан үед гал нилдээ авалцахаас өмнө үнэртэх эсвэл олж харах боломж олдохгүй. Тиймээс галын дохиолол нь мөн дотуур байранд унтаж байгаа төдийгүй ойр орчмын байшинд байгаа ажилчдыг сээрэж чадна. Галын дохиолол хэвийн ажиллагаатай, батарей нь ажиллаж байгаа эсэхийг тогтмол шалгаж баталгаажуулж бай;

- Гарц гадагш гарах хаалгыг хүмүүс байшин дотор ажиллаж байх үед үргэлж онгорхой байлга. Гарц нь сайтар гэрэлтүүлэгтэй, тэмдэглэгээтэй байх хэрэгтэй. Олон давхар байшинд шат нь гарах гарц болдог тул сайн гэрэлтүүлэгтэй, өргөн, олон ажилчдыг аюулгүй гаргах даацтай байх хэрэгтэй;

- Нээлттэй дамжин өнгөрөх зам** нь шууд гарах гарц руу хөтөлдөг. Дамжин өнгөрөх хэсэг нь 1 метр өргөн байх ба илүү том ажлын байранд түүнээс ч өргөн байх хэрэгтэй. Дамжин өнгөрөх хэсэг нь хайрцааг, сав байхгүй цэвэр байх нь маш чухал юм;



Дотуур байр, үйлдвэрээс хөрхэн аюулгүй, хурдан гарч хаана уулзах талаар дадлага хийх нь жинхэнэ гал гарсан үед хүмүүс сандрахгүй байхад тус болдог. Үйлдвэртээ “галын аюулын дадлага” зохион байгуулж бай.

- Таазны ус цацах систем** нь утаа илрүүлэгчтэй байх ба усны шугам нь ахиухан устай байна. Ус шүршигч нь гал гарсан үед автоматаар ажиллаж эхэлдэг байх хэрэгтэй;
- Галын хор** нь үйлдвэрт заавал байх шаардлагатай. Тэдгээр нь сайтар тэмдэглэгдсэн, хүрэхд хялбар, тогтмол шалгадаг ба хугацаа нь дууссан үед шинэчилдэг байх хэрэгтэй. Галын хорыг жижиг гал гарсан үед унтраах, тархахаас хамгаалахад хэрэглэнэ. Усны

хувин нь ихэвчлэн гал унтраахад хангалттай байдаггүй ба мөн цахилгаанаас, химийн бодисоос эсвэл тосноос үүссэн галд хэрэглэх нь аюултай байдаг.

Бүх ажилчид галын хорыг хэрхэн ашиглах талаар мэдэх эсэхийг баталгаажуулаарай. Галын хорыг хэрэглэх үедээ та нэг талдаа гал нөгөө талдаа аврах гарц байлгаж, гал дэгдэн унтрааж чадахааргүй болох үед галд хоригдохгүйгээр бай. Гал унтраах үүрэг гүйцэтгэж, дадлага хий.



Галын хорыг  
галын төв цэг рүү  
чиглүүлэн шүрш

Галын хор нь бага зэргийн  
галыг хурдан хугацаанд  
унтрааж чадна.

Гал асахад гурван зүйл хэрэгтэй байдаг:

- Гал, оч эсвэл гал эхлүүлэх ямар нэг халуун зүйл;
- Шатах (материал) түлш;
- Хүчилтөрөгч галыг үргэлжлэн шатах нөхцөлийг бүрдүүлдэг.

Гал асахад хэрэгтэй зүйлсийн аль нэгийг нь хаах юм уу, авах үед гал үргэлжлэн шатахаа больдог. Галыг хэрхэн унтраах арга замыг мэддэг байх, дадлага хийж байх нь чухал ч, гал гарсан үед хэрхэн хурдан хугацаанд үйлдвэрээс гарахыг мөн дадлагажуулах хэрэгтэй.

### **Үйлдвэрийн гал түймэр: Урьдчилан сэргийлж болохуйц сүйрлүүд**

#### **Нью-Йорк, 1911 он**

АНУ-ын Нью-Йорк хотын Triangle Shirtwaist үйлдвэрт 1911 оны гуравдугаар сарын 25-ны өдөр 500 цагаач эмэгтэй ажиллаж байх үед гал гарсан юм. Тэд гарахыг хичээсэн боловч хаалга нь цоожтой байжээ. Галын аюулаас аврах гарц нь маш тааруухан байсан тул нурсан юм. Бусад ажилчид нь галаас зугтахын тулд 9 давхрын цонхинос гудамж руу үсэрч байв. Ердөө 25 минутын дотор 146 эмэгтэй ажилчин нас барав.



Энэ компанийд гарсан гал түймэр үйлдвэрүүд ямар аюултай байгааг ойлгуулж, ажилчид нэгдэн АНУ-ын Засгийн газарт галын аюулгүй байдлын тухай хууль батлахыг шахаж, шаардсан юм.

#### **Бангкок, 1993 он**

Тайландын Бангкок хотын Кадерийн тоглоомын үйлдвэрт 1993 оны тавдугаар сарын 10-ны өдөр агуулахын цонхинос гал нэвтрэн гарч ирсэн юм. Барилгын галын аюулгүйн дохиолол ажиллаагүй байсан ба ажилчдад захиалгаа дуусгахын тулд үргэлжлүүлэн ажилла гэж хэлж байжээ. Гал маш хурдан тархсан байна. Ажилчдыг цоожлон илүү цагаар хүчээр ажиллуулдаг байсан ба тэнд мөн галын аюулгүйн гарц болон галын хор байгаагүй юм.

(ургэлжлэл)



Нийтдээ 188 хүн нас барж, олон зуун хүн гэмтэл авсан байна. Амьд үлдэгсэд, гэрчүүд, тэдгээрийн гэр бүл уур хилэн, уй гашуугаараа аюулгүй байдлын төлөө тэмцэхэд нь AN-REOV, Мэргэжлийн болон Байгаль орчны Хохирогчдын Эрхийг хамгаалах Азийн Сүлжээ тусалсан байна.

### **Дака, 2012 он**

Бангладешийн Дака хотын Тазреегийн үйлдвэрт 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр догшин гол дүрэлзэж, 100-аад хүн нас барсан ба тэдгээр нь Валмарт болон бусад брэндийн хувцсыг цоожтой хаалганы ард үйлдвэрлэж байсан ажилчид юм. Хэдхэн сарын өмнө Валмартын төлөөлөгч Бангладешийн Хувцас Үйлдвэрлэгч, Экспортлогчдын Холбоонд энэ хувцасны үйлдвэрт голын аюулгүйн систем байрлуулах нь хэтэрхий үнэтэй байна гэж хэлж байсан ажээ.

Орон нутгийн үйлдвэрүүд, олон улсын томоохон брэндүүд нь бага хөлсөөр их ашиг олохоосоо илүү ажилчдын үнэ цэнэтэй амь насанд санаа тавих ёстой. Тэр болтол урьдчилан сэргийлэх боломжтой үйлдвэрийн гол түймрээс болж ажилчид амиа алдсаар байгаа нь харамсалтай.

### **Үйлдвэрийн гол түймэрт хэн буруутай вэ**

*“Брэндийн үндсэн хэлтэс буруутай. Тэд л бүгдийг бага зардлаар үйлдвэрлэхийг шахаж байдал. Та нэг компанийн хэлтэст шударга цалин авах үйл ажиллагааг дэмжиж байгаа ч яг хажуугийн орөөнд чинь үндсэн хэлтсээс 10 хувиар бага цалинтай ажиллах уу гэж асууж л байдал”.*

-Хөдөлмөрийн зохион байгуулагч

*“Брэндийг худалдан авагчид буруутай. Тэд хэлэхдээ ажиллах нөхцөлийг сайжруулж байгаа, тэд сайн компани гээж үйлчлүүлэгчдэд хэлдэг. Гэвч ердөө хэдхэн центийг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч ажилчдынхаа сайн сайхны төлөө нэмж төлөхийг хүсэхэд тэд эдийн*

*засаг мүү байна гэдэг. Бид тэднийг маш их мөнгө олж байгааг нь харсаар байдаг.”*

-Хөдөлмөрийн яам

*“Хөдөлмөрийн яам буруутай. Хэн ч надад онцгой үед ашиглах аюулгүйн гарц сууринуул гэж хэлээгүй шүү дээ. Хэрэв хэн нэгэн нь ингэх хэрэгтэй гэж хэлсэн бол би хийчих л байсан. Надад хэн ч заавал хийх хэрэгтэй гэж хэлээгүй байхад би яагаад буруутай гэж?”*

-Үйлдвэрийн эзэн

*“Эзэд нь буруутай. Үйлдвэрүүд аюулгүй болох хүртлээ хаалттай байх хэрэгтэй. Гэвч эзээс их юм шалтгаалдаг. Тэд засгийн газарт мөнгө төлдөг.”*

-Галын ажилтан

## Гэртээ ажиллах үед галын аюулаас урьдчилан сэргийлэх

Бараа үйлдвэрлэх ажлыг гэртээ хийдэг бол галын аюул түргэн тархах аюултай. Ихэвчлэн тааруу, хэт ачаалсан цахилгааны холболт болон маш их шатах материал байдаг учраас аюултай. Хэрэв та үйлдвэрийн ажлыг гэртээ хийдэг бол:

- Химиин бодисыг ил галаас хол байлгаж, гэр дотор тамхи татахгүй байх;
- Та болон таны хөрш уусгагч болон бусад шатамхай материалыг төмөр сав эсвэл торхонд хадгалах ёстой;
- Цонх, хаалгаа онгорхой байлгаж, агааржуулж байх ба сэнс ашигла;
- Хэрэв гал хоолны савнаас гарсан бол түүнийг тагаар дарж бүтээ;
- Ялангуяа химиийн бодис эсвэл цахилгаанаас үүдэлтэй гал гарвал, түүнчлэн мод эсвэл даавуунаас болж гал гарсан бол хувин элс болон шороо бэлэн байлга. Усны даралт хэт бага үед усны хоолойд (зөвлөн) найдах боломжгүй байдаг;
- Ажил олгогчоосоо галын хор асуу. Хэрэв тэр өгөхгүй бол өөртөө гэртээ хэрэглэх нэг жижгийг хийж болно (доор үзүүлэв);

- Гэрээс чөлөөтэй гарах гарц байлга.

Галд бэлэн бай. Хэрэв танай эргэн тойрон гал дэгдвэл яах талаар хөрштэйгээ зөвлөлдөн төлөвлө.



- Гал гарсан талаар хүмүүст мэдэгд.** Төмөр хоолой, яндан цохин аюулын харангдаа дуугаргаж, бүх хүнд аюулыг мэдэгд;
- Галтай хэрхэн тэмцэхээ төлөвлө.** “Хувинтай бригад” болгон хүмүүсийг зохион байгуулж тэднээр хувинтай ус, элс эсвэл шороо авчруул;
- Дараа нь хаана уулзах талаар.** Парк эсвэл том байшинг нэрлэн тэндээ ямар нэгэн онцгой байдал гарвал уулзана гэж зөвшилцэн шийдэж, дараа нь бүгд хэвиийн байгаа эсэхийг шалгаж бай.

## Хэрхэн

## Гэртээ галын хор хийх

Хэрэгтэй зүйлс:

- Хагас литр эсвэл түүнээс илүү багтаамжтай усны хуванцар сав;
- Ус;
- Цуу (ямар ч төрлийн байж болно);
- Хүнсний соод (солиум бикарбонат);
- Жижиг хуванцар савыг тойрог маягаар 3 инч буюу 15 см диаметртэй хайчил;
- Хадаас, шүрүүп эсвэл зҮҮ;
- Скоч.




**1.** Хуванцар савны 1/2-д ус хий. Үлдсэн ихэнх хэсгийг нь цуугаар дүүргэх ба гэхдээ 3 см орчим зайд дээд хэсэгт нь үлдээ.

**2.** Тойрог хэлбэртэй хуванцраа савны онгорхой хэсэгт байрлуул. Тойрог хэсгийн голыг хуруугаараа дарж, савны амсарт оруул. 2-4 халбага дүүрэн хүнсний соод дотор нь хийж хуруугаараа хуванцар хэсгийг түлхэн савыг дүүртэл гүн хий. Хуванцрын төгсгөл хэсгийг конус хэлбэртэй болгож ороо, ингэснээр савны тагийг шүрүүпдэх боломжтой болно.



Хүнсний соод саванд оронгутут шууд тагла.

- 3.** Савыг сайтар таглаж, босоо байдалд хадгал.  
Боосон хүнсний соод шингэний дээр байх болно.  
Саванд хадаасыг скочоор нааж байрлуул.



Хэд хэдийг урьдчилан бэлтгэ.

**Хэрэглэхдээ,** савыг хүчтэй сэгсэрснээр хүнсний соод, цуу, ус хурдан холилдоно. Хөөсөрч эхлэхийг нь харах үедээ (савны нимгэн хэсгийг барьж үзэж байгаад) доод хэсэгт нь цоолж гал руу чиглүүлэн шүршинэ. Шүршиж байх үедээ үргэлжлүүлэн сэгсрээрэй.

## Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусlamж

**Ямар ч түлэгдэлтэд,** түлэгдсэн хэсгийн арьсны ойр орчмоос хувцас, үнэт эдлэлийг авч, (мөстэй биш) хүйтэвтэр усанд дор хаяж 30 минут байлга.

**Жижиг түлэгдэлтэд** цэврүүтэхээргүй жижиг бол: хүйтэвтэр усанд тэр даруй түлэгдсэн хэсгийг дүр. Ингэснээр өвдөлтийг багасгаж, гэмтлийн талбайг багасгана. Түлэгдсэн үед өвдөх учраас шаардлагатай бол өвчин намдаагч хэрэглэ.



**Халуун ус эсвэл тосонд түлэгдвэл:** халуун ус, тос болсон хувцсыг тайл. Яаралтай хүйтэвтэр усанд түлэгдсэн хэсгийг дүрж зайл.

**Цэврүүтэлт үүсэхээр түлэгдэлт бол:** түлэгдсэн хэсгийг яаралтай хүйтэвтэр усанд байлга. Цэврүүг хагалж болохгүй. Хэрэв цэврүү хагарвал, зөөлөн саван болон усаар маш зөөлөн угаах, гэхдээ халдвартгүйжүүлэгч эсвэл иод хэрэглэж болохгүй. Түлэгдсэн хэсгийг цэвэр байлгаж шороо, тоос, антибиотикийн тос эсвэл зөгийн балаар ялаанаас хамгаалж, ариутгасан самбай, бинтээр мөн хамгаал. Хэрэв эдгэрэлт удаан эсвэл арьс улаан, хавдсан хэвээр юм уу, өвдсөн хэвээр байвал эмчид үзүүл. Танд магадгүй халдвартын эсрэг эмчилгээ хэрэгтэй байж мэднэ.



Анхны тусlamж

(үргэлжлэл)



Анхны  
тусламж

**Химиин бодисын түлэгдэл:** 8-р бүлэг. Химиин бодисын аюул, 239 дүгээр хуудаснаас үзнэ үү.

### Яаралтай эмнэлгийн тусламж авах бол:

- **Том эсвэл гүн түлэгдэл:** биеийн томоохон хэсгийг хамарсан түлэгдэлт эсвэл арьсыг махыг нь гартал улайлгасан болон мах руу шигдсэн түлэгдэлт нь үргэлж ноцтой байдаг;
- **Үе мөч, нүүр эсвэл бэлэг эрхтэнд хүрсэн түлэгдэл:** эдгээр нь хөдөлмөрийн чадвар алдахад хүргэж болно;
- **Бусад гэмтэлтэй хосолсон түлэгдэлт**
- **Хүүхэд түлэгдсэн бол:** хүүхэд нь том хүнийг бодвол түлэгдэлтээс эдгэрэх нь илүү хэцүү байдаг.

**Анхаарах зүйл:** хэзээ ч түлэгдсэн хэсэгт тос, амьтны гаралтай өөх тос, амьтны арьс, кофе, ургамал эсвэл ялгадас хүргэж болохгүй. Ингэх нь арьсны эдгэрэлтэд муугаар нөлөөлж, халдварт оруулах болно.

### Утаа амьсгалах

Утаагаар амьсгалах нь уушгийг түлж болох бөгөөд энэ нь маш ноцтой гэмтэл. Амьсгалаад хүндрэлтэй, уушги шатаж байгаа мэт мэдрэмж төрөх, цээж бачуурах эсвэл хүндээр ханиалгаж байвал яаралтай эмнэлгийн тусламж ав.

Ойрхон гал гарсан бол ам хамраа дар.